


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны өдрөөс 05 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар буюу **эпидемиологийн 1-20 дугаар долоо хоногт** нийт Нийслэлийн 7 дүүрэг, 8 аймагт **1284** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 1284 тохиолдлын 94% /1214/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 6% /70/ нь орон нутагт (Баян-Өлгий /30/, Дорнод /3/, Орхон /11/, Өмнөговь /1/, Сэлэнгэ /6/, Төв/16/, Дорноговь /2/, Баянхонгор /1/) бүртгэгдсэн байна.



Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу 358 тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

ЭПИДЕМИОЛОГИЙН **20** ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2025.05.11 – 05.17)

2025 оны эпидемиологийн 20 дугаар долоо хоногт угаарын хийн хордлогын **112** тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 7 дахин, сүүлийн 5 жилийн дунджаас 3 дахин тус тус өссөн байна.




ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **эпидемиологийн 1-20 дугаар долоо хоногт нийт 538** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.


315Эмнэлгийн
тусламж авч буцсан**223**Хэвтэн эмчлүүлж
эдгэрч гарсан**0**

Нас барсан

Эрэгтэй
46%Эмэгтэй
54%

Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 буюу бага насны хүүхдүүд хамгийн их хордлогод өртөж байна.

2025 оны **эпидемиологийн 20 дугаар долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **25** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь сүүлийн 5 жилийн дунджаас 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (Эпи – 20 долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	3	6	9
2	Эмийн хордлого	5	11	16
Нийт		8	17	25

Тухайн долоо хоногт химийн бодисын хордлогод **санамсаргүйгээр** өртсөн тохиолдлууд зонхилж байгаа бөгөөд шалтгаанаар авч үзвэл витамин, харшил, ханиадны эм болон будаг шингэлэгч, цемент цэвэрлэгч, шингэн саван, аяга таваг угаагч зэрэг ахуйн болон цэвэрлэгээний зориулалттай бүтээгдэхүүнүүдэд хордсон байна. **Санаатайгаар** өртсөн тохиолдлуудыг авч үзвэл 10-35 насны хүмүүс байгаа бөгөөд будаг шингэлэгч үнэрлэсэн, олон тооны эм уусан байна.

-o0o-